



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/15

Өвт

Хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын 6.1, 6.2, 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий өвчний сэжигтэй тохиолдлууд бүртгэгдсэн тул 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаагаар хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын дэглэм тогтоосон үед ажиллах малын гоц халдварт шүлхий өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий тандалт мэдээллийн багийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

1,6 дугаар багт: Л.Батчулуун (Засаг даргын орлогч)
Ж.Нямтогтох (багийн Засаг дарга)
Д.Дэмиддагва (багийн Засаг дарга)
Г.Баярсайхан (жолооч)

2 дугаар багт: Р.Даваасүрэн (Тархвар зүйч)
Д.Бямбасүрэн (багийн Засаг дарга)
Ц.Нансандаваа (жолооч)

3,4, 5 дугаар багт: Л.Балжинням (багийн Засаг дарга)
С.Төмөр (багийн Засаг дарга)
Г.Пүрэвтогтох (багийн Засаг дарга)
П.Содномбалжир (“Хутаг уулын өгөөж” Мал эмнэлгийн
малын эмч)


3. Малын гоц халдварт шүлхий өвчин тархахаас хамгаалах, хязгаарлалтын дэглэм сахиулах, малын гоц халдварт шүлхий өвчний талаарх мэдээллийг малчдад хүргэх, үнэн зөв мэдээллээр хангах, малчдыг малаа байнгын хариулгатай байлгахад хяналт тавьж ажиллахыг Тандалт мэдээллийн багийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

4. Шүлхий өвчин халдварласан байж болзошгүй малд тандалт, үзлэг хийж, ариутгал халдваргүйжүүлэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг “Хустын рашаан” мал эмнэлэг (Л.Батбилэгт)-д үүрэг болгосугай.

622101029

5. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан ерөнхий удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



A handwritten signature in black ink, appearing to read 'S. Amgalan', is written over a faint red rectangular stamp. The stamp contains some illegible text and numbers.

С.АМГАЛАН